

МОНТО ХХК (MONTO, s.r.o.) -ийн ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Ческе Будеёовице хот дахь Аймгийн шүүхийн Аж ахуйн нэгжийн бүртгэлийн С хэсгийн 8446 дугаарт бүртгэгдсэн, улсын бүртгэлийн 251 85 799 дугаартай, Ческе Будеёовице 4-р дүүрэг, Жеротинова гудамжны 503/5 тоот хаяг, 370 04 шуудангийн дугаартай МОНТО ХХК (цаашид "Компани" гэх) компанийн

интернет хаяг дээр байрлах SimpleGate интернет порталаар дамжуулан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хүний хувийн мэдээллийг боловсруулахад баримтлах зарчим.

1. Удиртгал зохицуулалт

- 1.1. Энэхүү хүний хувийн мэдээллийг хамгаалах зарчим (цаашид „Зарчим“ гэх) нь Компани таны хувийн мэдээллийг хэрхэн цуглуулах, хадгалах, боловсруулах, дамжуулах талаар танд мэдээлнэ. Энэхүү Зарчим нь Веб сайт (цаашид „Веб сайт“ гэх) -аар танд үйлчилгээ үзүүлэх хүний хувийн мэдээллийг хамгаалах журамд хамаарна.
- 1.2. Энэхүү зарчим нь Компанийн ерөнхий худалдааны нөхцөл (цаашид „Нөхцөл“ гэх) -ийн үргэлжлүүлэл бөгөөд энэхүү зарчимд тодорхойлоогүй нэр томъёог Нөхцөлд заасан утгаар ойлгож ашиглана.
- 1.3. Энэхүү зарчим нь Компанийн Нөхцөлийн салшгүй хэсэг юм. Хэрэглэгч бүртгүүлэхээсээ өмнө энэхүү Зарчимтай танилцах үүрэгтэй. Бүртгүүлснээр Хэрэглэгч энэхүү Зарчмыг зөвшөөрч байгаагаа илэрхийлнэ. Хэрэв Хэрэглэгч энэхүү Зарчмыг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд Компанид тэр даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 1.4. Компани нь энэхүү Зарчмыг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бие даан нэмж, өөрчилж болно. Зарчимд оруулсан нэмэлт өөрчлөлт нь таны хувийн мэдээллийг боловсруулах аргад эрс нөлөөлсөн эсвэл таны эрхийг хязгаарласан бол Компанийн зүгээс танд мэдэгдэл (жишээ нь цахим шуудангаар) илгээнэ.
- 1.5. Хүний хувийн мэдээллийг боловсруулах, ялангуяа хувь хүнийг хамгаалах, хувь хүний мэдээллийг дамжуулах үйл ажиллагааг Европын парламент ба Зөвлөлийн (ЕХ) 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн 2016/679 тоот журам, болон 95/46/ЕС (Хүний хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журам) (цаашид „GDPR“ гэх) удирдамжийг хүчингүй болгох тухай болон Хувийн мэдээллийг боловсруулах тухай Хуулийн эмхэтгэлийн 110/2019 тоот хууль, түүний сүүлийн нэмэлт өөрчлөлтийн дагуу (цаашид „ZZOU“ гэх) зохицуулна.
- 1.6. Энэхүү Зарчим нь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд GDPR-ийн 13, 14 дүгээр зүйлд заасны дагуу Компани мэдээлэл боловсруулах үүргээ биелүүлэх зорилгоор боловсруулсан.
- 1.7. Компани тантай хамтран ажиллах явцад танаас цуглуулсан таны бүх хувийн мэдээллийн хариуцагч нь байна. Хүний хувийн мэдээллийн хариуцагч нь хувийн мэдээллийг боловсруулах зорилго, аргыг тодорхойлдог байгууллага юм. Компанийн зааврын дагуу таны хувийн мэдээллийг боловсруулдаг аливаа гуравдагч этгээд Компанид үйлчилгээ үзүүлэгч буюу хувийн мэдээллийн "боловсруулагч" болно.
- 1.8. Компани хувийн мэдээллийг хамгаалах итгэмжлэгдсэн төлөөлөгчгүй. Компани таны хувийн мэдээллийг нууц мэдээлэл гэж үзэж, аюулгүй байдлыг нь хариуцаж ажиллана.

- 1.9. Компани автоматжуулсан тохируулга эсвэл профайл дээр үндэслэн шийдвэр гаргахгүй.
- 1.10. Энэхүү Зарчмын талаар асууж тодруулах зүйл байвал, хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой Компанийн журмын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, хувийн мэдээллээ боловсруулахтай холбоотой эрхээ хэрэгжүүлэхийг хүсвэл та Компанитай цахим хаягаар холбогдож болно.

2. Компанийн цуглуулж, хадгалдаг мэдээлэл

- 2.1. Хүний хувийн мэдээлэл нь тодорхой хувь хүнийг шүүд болон шүүд бусаар тодорхойлох боломжтой мэдээлэл юм. Компани нь дараах мэдээллийг цуглуулж, хадгалж болно. Үүнд:
- (i) **Таны өгсөн мэдээлэл.** Компанид Веб сайт дахь маягтаар хэрэглэгчийн мэдүүлсэн, эсвэл Компанийн Веб сайтыг бус хэлбэрээр (мобайл төхөөрөмж ашиглаж гэх мэт) хэрэглэгчийн мэдүүлсэн хэрэглэгчийн хувийн мэдээллийг Компани цуглуулна.
 - (ii) **Гүйлгээний өгөгдөл.** Компаний Веб сайтаар Хураамж төлөхөд шаардагдах мэдээллийг цуглуулдаг.
 - (iii) **Бүртгэлийн өгөгдөл.** Компанийн Веб сайтыг ашиглахад Компани таны мэдээлэл болон таны үйлдлийг (нэвтрэх өгөгдөл) автоматаар бүртгэнэ. Бүртгэлийн мэдээлэлд таны төхөөрөмжийн интернэт протокол ("IP") хаяг, хөтчийн төрөл, вэб сайтаас хайсан мэдээлэл багтаж болно.
 - (iv) **Гуравдагч талын үйлчилгээ.** Компани цуглуулсан мэдээллээ боловсруулах, хадгалах, үнэн зөв байдлыг бататгах, мөн Веб сайт, үйлчилгээгээ оновчтой болгохын тулд таны нийтэд нээлттэй мэдээллийг гуравдагч этгээдээс цуглуулж болно.
 - (v) Та болон Компанийн хооронд Гэрээ байгуулахад таны хувийн зарим мэдээлэл (зураг, хүйс, үргийн овог, овог, нэр, төрсөн огноо, цол зэрэг, оршин суугаа хаяг, иргэншил, и-мэйл, утасны дугаар, боловсролын зэрэг, зорчих газар) шаардлагатай. Бусад бүх хувийн мэдээллээ (жишээ нь, гэрлээгүй үеийн овог нэр, гадаад паспортын дугаар, цалингийн төсөөлөл, салбар) өгөх нь сайн дурын боловч Компанийн веб сайт, үйлчилгээ эсвэл бусад үйлчилгээг ашиглахад эдгээр мэдээлэл шаардагдаж болно.

3. Күүкийг ашиглах дүрэм

- 3.1. Хэрэглэгчдэд Веб сайтаар үйлчилгээ үзүүлэх, контентыг ашиглах боломжтой болгохын тулд Компани Веб сайт дээрээ күүки ашигладаг. Күүки нь Веб сайтыг нээх үед таны төхөөрөмжид татагдах бага хэмжээний мэдээлэл агуулсан текст файл юм. Таныг дараа нь интернетд хайлт хийхэд Күүки таныг таньж бүртгэн Веб сайт руу таныг шууд чиглүүлдэг. Күүки төрөл бүрийн даалгавруудыг гүйцэтгэдэг; жишээ нь, Веб сайтуудын хооронд навигац хийх, таны хайлт, сонголтуудыг санах, хэрэглээг бүхэлд нь шуурхай, оновчтой болгох зэрэг болно. Мөн таны онлайнаар харж буй зар сурталчилгааг таны сонирхолд нийцэх эсэхийг тодруулна.
- 3.2. Бид Веб сайт дээрээ дараах Күүкиг ашигладаг:
- (i) **Техник күүки** - Зайлшгүй байх ёстой күүки, Хэрэглэгч идэвхгүй болгох боломжгүй. Эдгээр нь системийн хэвийн үйл ажиллагаанд ашиглагддаг нэргүй күүки, өөрөөр хэлбэл ялангуяа:

- хэрэглэгчийн нэвтрэх,

- Компаниас үйлчилгээ авах хүсэлт гаргах боломжтой,
 - төлбөрийн аргыг сонгох.
- (ii) **Аналитик күүки** – Веб сайтын ажиллагааг хянах (зочдын тоо, хийсэн үйлдэл гэх мэт) мөн зар сурталчилгаатай холбоотой мэдээллийг хадгалах боломжийг олгодог.
- (iii) **Хувийн болгосон күүки** – Зөвлөмж, санал гэх мэт хувийн өгөгдөлд тохирох мэдээллийг хадгалахад ашиглагддаг.
- (iv) **Зар сурталчилгааны күүки** – Компани эсвэл түүний түнш, гуравдагч этгээдийн веб сайт дээрх, хэрэглэгчийн сонирхол, хайлтад нийцэх агуулга, зар сурталчилгааг хэрэглэгчид харуулах зорилгоор ашигладаг.
- 3.3. Гуравдагч этгээдүүд (ихэнхдээ Компанийн аналитик болон зар сурталчилгааны үйлчилгээ үзүүлдэг Компанийн гэрээт түншүүд) мөн Веб сайтад байршуулсан күүки ашиглах ба/эсвэл күүкигээр цуглуулсан мэдээлэлд хандах боломжтойг анхаарна уу. Компани эдгээр күүкиг хянагч гуравдагч талын күүкиг унших, бичих эрхгүй.
- 3.4. Веб сайтад күүки байршуулдаг гуравдагч этгээдүүдийн талаарх мэдээллийг:
- 3.4.1. Google Ireland Limited, бүртгэлтэй хаяг: Ирланд, Гордон Хаус, Барроу гудамж, Дублин 4; тус Компанийн нүүцлалын бодлогыг <https://policies.google.com/technologies/ads> хаягаас авах боломжтой.
- Та күүкийг тухай болон түүний жагсаалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг интернет хөтчөөр дамжуулан, ихэнхдээ Хөгжүүлэгчийн хэрэглүүр хэсгээс авч болно.
- 3.5. Та бүх күүкийг (аналитик, хувийн болгосон, зар сурталчилгаа) боловсруулахыг зөвшөөрч байгаагаа илэрхийлж болно, хэрэв та Веб сайтад анх удаа эсвэл хамгийн сүүлд зочлох үедээ тайлбар хийгээгүй бол Веб сайтын доод хэсэгт гарч ирэх **күүки талбар** дээрх "Би зөвшөөрч байна" товчийг дарж болно.
- 3.6. Аналитик, хувийн болгосон мөн зар сурталчилгааны күүки боловсруулахыг татгалзах бол күүкийн талбар дээрх "Би санал нийлэхгүй байна" товчийг дарна. Гэхдээ бид таны зөвшөөрөлгүйгээр техникийн күүкиг боловсруулах боломжтой. Зөвшөөрөхгүй байх буюу татгалзах хугацаа дуусмагц зөвшөөрөл олгохыг хүссэн сануулга дэлгэц дээр удаа дараа гарч ирнэ.
- 3.7. Мөн та күүки талбар дээрх "Тохиргоо" товчийг дарж күүки боловсруулах зөвшөөрлөө өгөх боломжтой. Та хүссэн күүкигээ (аналитик, хувийн болгосон, зар сурталчилгаа) сонгохын тулд тэмдэглэгээ ашиглаж болно. Күүкигийн төрлийн талаар "Илүү их" гэсэн бичвэр дээр дарж дэлгэрэнгүй мэдэх боломжтой. Күүки ашиглах дүрмийг "Күүки ашиглах дүрэм" гэсэн холбоос дээр дарж хувийн мэдээллийг боловсруулах бодлогын ишлэлийг үзэж болно. "Би сонгосон күүки ашиглахыг зөвшөөрч байна" товчийг дарж сонголтоо баталгаажуулна уу. "Би бүх күүкиг ашиглахыг зөвшөөрч байна" товчийг дарж аналитик, хувийн болгосон болон зар сурталчилгааны күүки, эсвэл та эдгээр күүкиг боловсруулахыг зөвшөөрөхгүй "Зөвшөөрөхөөс татгалзах" товчийг дарж зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлж болно.
- 3.8. Та күүкийг боловсруулах тухай өмнө нь олгосон зөвшөөрлөө **цуцалж болох** бөгөөд Веб сайтын доод хэсэгт байрлах "Күүки тохиргоо" холбоос дээр дарж эсвэл хөтчөөс **күүкийг устгах** замаар цуцалж болно.
- 3.9. Та дараах холбоосууд дээр дарж хөтөч тус бүрийн күүкийн зохицуулалтын тараар дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

- Internet Explorer - <https://support.microsoft.com/cs-cz/help/17442/windows-internet-explorer-delete-manage-cookies>
- Google Chrome - <https://support.google.com/chrome/answer/95647?co=GENIE.Platform%3DDesktop&hl=cs>
- Mozilla Firefox - <https://support.mozilla.org/cs/kb/povoleni-zakazani-cookies>
- Apple Safari - <https://support.apple.com/cs-cz/guide/safari/sfri11471/mac>
- Opera - <https://help.opera.com/cs/latest/security-and-privacy/>
- Microsoft Edge - <https://docs.microsoft.com/cs-cz/sccm/compliance/deploy-use/browser-profiles>

3.10. Техникийн күүкигээс бусад күүкиг GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн а) хэсэгт заасны дагуу таны зөвшөөрлийг үндэслэн боловсруулна. Дээр дурдсанчлан та энэ зөвшөөрлөө хүссэн үедээ цуцлах боломжтой. Ийнхүү цуцлах нь цуцлагдах хүртэл хугацаанд күүки ашиглах хууль ёсны эрх, хэрэгжилтэд нөлөөлөхгүй. Та мөн күүки ашиглахыг татгалзах болно. Мөн Хувийн мэдээлэл боловсруулах зарчмын дагуу та өөрт хамаарах бүх эрхийг эдэлнэ.

3.11. Аналитик, хувийн болгосон болон/эсвэл зар сурталчилгааны күүкиг хадгалах зөвшөөрлийг **12 сарын** хугацаанд олгоно. Күүки ашиглан хувийн мэдээллийг боловсруулах зөвшөөрөл олгохоос татгалзвал тус **күүкигийн хамгийн сүүлийн шинэчлэлтээс хойш 6 сарын дараа** дахин зөвшөөрөл олгох шаардлагатай болно. Энэхүү хугацаа нь хувийн мэдээлэл боловсруулахтай холбоотой нэг буюу хэд хэдэн нөхцөл мэдэгдэхүйц өөрчлөгдсөн эсвэл Компани өмнөх зөвшөөрсөн/зөвшөөрөөгүй байдлыг хянах боломжгүй бол (жишээ нь, хэрэглэгч төхөөрөмж дээрээ хадгалсан күүкигээ устгасан) дээр заасан хугацаанаас богино байж болно.

4. Компани хувийн мэдээллийг хэрхэн ашигладаг тухай

4.1. Таны хувийн мэдээллийг дараах зорилгоор ашиглаж болно. Үүнд:

Компани танд үйлчилгээ үзүүлэх боломжтой болох. Таны хүссэн үйлчилгээг үзүүлэхийн тулд Компани таны хувийн мэдээллийг (очих газар, үргийн овог, овог, нэр, төрсөн огноо, гэрэл зураг, цол, зэрэг, оршин суугаа хаяг, иргэншил, цахим шуудангийн хаяг, утасны дугаар, боловсролын зэрэг, эсвэл гэрлээгүй үеийн овог, гадаад паспортын дугаар, цалингийн тухай төсөөлөл, салбар) боловсруулдаг. Компани таны хүсэлтийн дагуу эдгээр мэдээллийг гуравдагч этгээд (жишээлбэл, татварын албатай) эсвэл Компанийн харилцагч болон түншүүдэд Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хэмжээгээр дамжуулна. Таны хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулахгүйгээр компани танд үйлчилгээ үзүүлэх боломжгүй. Ийм учраас та Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, эсвэл Компанитай гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэх үүргүүдийг биелүүлэх шаардлагатай. Үүнд GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн б) заалтыг үндэслэнэ.

Хэрэглэгчийн мэдээллийн санг сайжруулах. Компани Веб сайтын хэрэглээг (бүртгэхэд зарцуулсан хугацаа гэх мэт) тань бүртгэж, хянах бөгөөд энэ нь Үйлчилгээг ашиглахад шаардлагатай үйлдлүүдийг хийхэд тусална. Компани танд хамгийн сайн үйлчилгээ үзүүлэх сонирхолтой. Веб сайтыг ашиглахад хүндрэлтэй байгааг тань Компани олж мэдвэл Компаниас зөвхөн танд туслах зорилгоор и-мэйл эсвэл утсаар зөвлөмж илгээнэ. Ийм тохиолдолд боловсруулалт нь Компанийн хууль ёсны ашиг сонирхлын үүднээс, ялангуяа үйлчилгээний сайн түвшинг хадгалахад зайлшгүй шаардлагатай. Энэ нь Компанийн хууль

ёсны ашиг сонирхол, ялангуяа үйлчилгээний чанарыг хадгалах, төдийгүй тантай байгуулсан Гэрээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Үүнд GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн б) заалт ба/эсвэл GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн f) заалтыг үндэслэнэ.

Таны асуултанд хариулж, харилцагчийн үйлчилгээ үзүүлэх. Компанийн зүгээс тантай холбогдож санал хүсэлт авах, зөрчил эсвэл асуудал шийдвэрлэх зорилгоор таны хувийн мэдээллийг (ургийн овог, овог, нэр, цол, зэрэг, и-мэйл хаяг, утасны дугаар зэрэг) ашиглана. Таны хувийн мэдээлэлгүйгээр Компани танд хариу өгөх эсвэл Үйлчилгээгээ үзүүлэх, үргэлжлүүлэн үзүүлэх боломжгүй. Ийм учраас та Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, эсвэл Компанитай гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэх үүргүүдийг биелүүлэх шаардлагатай. Үүнд GDPR -ийн 6 дугаар зүйлийн 1-ийн б) заалтыг үндэслэнэ.

Компанийн нөхцөл, Гэрээ, Зарчмыг хэрэгжүүлэх. Таны хувийн мэдээллийг (овог, нэр, төрсөн огноо, оршин суугаа хаяг, иргэншил, дансны дугаар зэрэг) Нөхцөл, Гэрээ, Зарчмын зөрчлийг мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх, багасгах зорилгоор; Компанийн гуравдагч этгээд, түншүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах; мөн Компанийн Үйлчилгээг ашигласны үндсэн дээр танаас хураамж авах зорилгоор боловсруулж ашиглана. Таны хувийн мэдээллийг дээрх зорилгоор боловсруулж ашиглахгүйгээр Компанийн зүгээс Нөхцөл, Зарчмын дагуу Үйлчилгээг үзүүлэх боломжгүй. Таны хувийн мэдээллийг боловсруулж ашиглах нь тантай байгуулсан Гэрээг биелүүлэх, эсвэл Компанийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй шаардлагатай болно. Ингэхдээ GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн б) заалт ба/эсвэл GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн f) заалтыг үндэслэнэ.

Үйлчилгээний аюулгүй байдлыг хангах. Компани таны хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, Компанийн Үйлчилгээг тасралтгүй үзүүлэх үүрэгтэй. Энэ зорилгоор Компани нь таны хувийн мэдээллийг (жишээ нь Веб сайт дээрх таны үйл ажиллагаа гэх мэт) дараах зорилгоор боловсруулдаг. Үүнд: спам, хортой программ хангамж, хортой үйл ажиллагаа эсвэл аюулгүй байдлын эрсдэлтэй тэмцэх; Компанийн аюулгүй байдлын арга хэмжээг сайжруулах, хэрэгжүүлэх; зөвшөөрөлгүй хэрэглэгчдийг Компаний таны данс руу нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд таны хувийн мэдээллийг хянах, баталгаажуулах. Компани аюулгүй байдлыг хангах зорилгоор таны хувийн мэдээллийг боловсруулахгүйгээр Үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж чадахгүй. Иймээс таны нэг тал нь болж буй Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд таны хувийн мэдээллийг боловсруулах зайлшгүй шаардлагатай. Ингэхдээ GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн б) заалтыг үндэслэнэ.

Хууль эрх зүйн тогтоомж, зохицуулалтыг дагаж мөрдөх. Компанийн үйлчилгээ нь хууль эрх зүйн тогтоомж, зохицуулалтад захирагдах бөгөөд үүний дагуу Компаниас таны хувийн мэдээллийг боловсруулах шаардлагатай. Таны хувийн мэдээллийг (жишээ нь, овог, нэр, төрсөн огноо, оршин суугаа хаяг, иргэншил, гадаад паспортын дугаар зэрэг) Компанийн бизнесийн үүргээ биелүүлэх, хууль эрх зүйн зохицуулалтыг дагаж мөрдөх, татвар төлөх зорилгоор ашиглах бөгөөд үүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрсдлийн удирдлагад шаардлагатай тул таны хувийн мэдээллийг боловсруулдаг. Ийм учир таны хувийн мэдээллийг боловсруулахгүйгээр Компани нь хууль тогтоомжийн шаардлагын дагуу үйлчилгээ үзүүлэх боломжгүй. Ашиг сонирхол нь үндсэн эрх, эрх чөлөөнөөс давах бусад тохиолдолд Компанийн хууль ёсны үйл ажиллагаа, ашиг сонирхлын үүднээс хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах зайлшгүй шаардлагатай. Ингэхдээ GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн f) заалтыг үндэслэнэ.

Үйлчилгээний хүрээнд хэрэглэгчийн мэдээллийн санг хянаж хувийн болгох. Компани гуравдагч талын үйлчилгээ, холбоос болон бусад олон төрлийн мэдээллийг танд өгнө.

Компанийн зүгээс мөн зорилгоор күүки файл болон ижил төстэй хяналтын технологийг ашиглана. Таны хувийн мэдээллийг боловсруулахгүйгээр та Үйлчилгээнд хэсэгчлэн болон/эсвэл бүхэлд нь нэвтрэх боломжгүй эсвэл Үйлчилгээг өөрчлөх боломжгүй болно. Ийм учраас та Гэрээгээр хүлээсэн үүрэг, эсвэл Компанитай Гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэх ёстой үүргүүдийг зайлшгүй биелүүлэх шаардлагатай. Ингэхдээ GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн б) заалт ба/эсвэл GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн f) заалтыг үндэслэнэ.

Маркетингийн үйл ажиллагаанд оролцох. Компани танд маркетингийн болон мэдээллийн талаар мэдэгдэл (бизнесийн мэдэгдэл) илгээж болно. Компани ЕХ-ны орнуудад оршин суух хувь хүмүүстэй Компанийн хууль ёсны ашиг сонирхлын дагуу, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, мөн хувь хүний зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн цахим хэрэгслээр (и-мэйл эсвэл SMS гэх мэт) холбогдоно. Компани хууль ёсны ашиг сонирхлынхоо дагуу Хэрэглэгчийн урьд өмнөх худалдаа эсвэл хэлэлцээрийн зүйлтэй ижил төстэй Үйлчилгээний талаарх мэдээллийг илгээнэ. Та хүссэн үедээ үнэ төлбөргүй маркетинг хийхийг шууд эсэргүүцэж болно. Энэ тохиолдолд хувийн мэдээлэл ашиглах эсэх нь Компанийн хууль ёсны ашиг сонирхол эсвэл таны урьдчилж өгсөн зөвшөөрлөөс шалтгаална. Таны зөвшөөрлийн дагуу ашиглагдаж байгаа бол GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн f) заалтын хүрээнд Мэдээллийн нийгмийн зарим үйлчилгээний тухай Хуулийн эмхэтгэлийн 480/2004 тоот хуулийн § 7 дугаар зүйлийн 2-р заалт, түүний сүүлийн нэмэлт өөрчлөлтийг үндэслэн боловсруулна. Хэрэв Компанийн хууль ёсны ашиг сонирхолдоо тулгуурласан бол GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн f) заалтыг үндэслэнэ.

Хувийн мэдээллийг тань ашиглах Компанийн үйл ажиллагааг хязгаарлахаар шийдсэн бол та Үйлчилгээг хэсэгчлэн болон бүхэлд нь ашиглах боломжгүй болно.

5. **Мэдээлэл хуваалцах, задруулах**

Компани Үйлчилгээ үзүүлэх, дүн шинжилгээ хийх, үйл ажиллагаагаа сайжруулах (мэдээлэл хадгалах, засвар үйлчилгээ, мэдээллийн сангийн удирдлага, веб аналитик, аюулгүй байдал, төлбөр боловсруулалт, Үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах гэх мэт) зорилгоор тодорхой итгэмжлэгдсэн компани болон гуравдагч этгээдийг ашигладаг. Жишээ нь, Компани таны зарим мэдээллийг хадгалахын тулд Microsoft Azure хадгалах үйлчилгээг ашигладаг бөгөөд танд явуулах нэхэмжлэл гаргахын тулд БӨГЛӨХ компанийн үйлчилгээг ашигладаг. Компанид зориулсан Google Analytics-ийн үйлчилгээ нь Гэрээний талуудын күүки файл, төхөөрөмж/хөтөч, IP хаяг болон Веб сайтын үйл ажиллагааны мэдээллийг цуглуулах бөгөөд энэ нь Веб сайтыг хэрхэн ашигласан тухай таны талаарх мэдээллийг хэмжих, шинжих, тайлагнах боломжийг Компанид олгодог. Веб сайт дээрх үйл ажиллагаагаа Google Analytics-д хэрхэн өртүүлэхгүй байх тухай мэдээллийг <https://support.google.com/analytics/answer/181881> Веб сайтаас авах боломжтой.

Компанийн гуравдагч талууд зөвхөн Компанийн нэрийн өмнөөс мөн энэхүү Зарчим, Нөхцөл эсвэл тантай байгуулсан Гэрээнд заасан үүрэг хариуцлагатай ижил төстэй ажил, үүргийн хүрээнд таны хувийн мэдээллийг авах, ашиглах эрхтэй байж болно.

Компанийн Веб сайт бусад гуравдагч талын үйлчилгээг таны бүртгэлд нэгтгэх боломжтой. Гуравдагч талууд таны хувийн мэдээллийг хэрхэн ашиглаж байгааг Компани хариуцахгүй бөгөөд эдгээр үйлчилгээг тус тусын үйлчилгээний нөхцөл, хүний хувийн мэдээллийг хамгаалах зарчмаар (жишээ нь Amazon) зохицуулна. Гуравдагч талд хувийн мэдээллээ дамжуулахаасаа өмнө хүний хувийн мэдээллийг хамгаалах зарчимтай нь үргэлж танилцах хэрэгтэй.

Хууль тогтоомж, хууль сахиулах байгууллагуудын шаардлагыг дагаж мөрдөх; хэрэглэгчийн эрхийг хамгаалах. Компани хууль ёсны үүргээ биелүүлэх, хууль тогтоомж эсвэл бусад хууль эрх зүйн шаардлагыг дагаж мөрдөхөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл таны Хэрэглэгчийн бүртгэлд хадгалагдсан файл болон таны тухай бусад мэдээллийг (ялангуяа, таны хувийн мэдээлэл) гуравдагч талуудад (ихэвчлэн албан байгууллага эсвэл шүүх) олгож болно.

Бизнесийн гүйлгээ. Компани хөрөнгөө хэсэгчлэн эсвэл бүхэлд нь нэгтгэх, худалдах, худалдан авах ажиллагаанд оролцож байгаа бол таны мэдээллийг энэхүү ажиллагааны нэг хэсэг болгон шилжүүлж болно.

Хувь хүний бус эсвэл хувийн эзэмшлийн бус мэдээлэл. Компанийн Үйлчилгээний статистик, нэгтгэл зэрэг хувь хүний бус мэдээллийг задруулж, арилжааны болон арилжааны бус зорилгоор Компани ашиглаж болно.

6. **Арилжааны мэдэгдлээс татгалзах**

Та Компанийн маркетинг болон бусад төрлийн мэдээлэл хүлээн авах сонголт хийсэн бол танд илгээх маркетинг болон бусад төрлийн и-мэйлүүдэд цуцлах сонголтыг хавсаргасан байна. Танд илгээж буй маркетинг болон бусад төрлийн мэдээллийн мэдэгдэл нь зөвхөн үйлчилгээ, сурталчилгааны зориулалттай байна.

Хэрэглэгчийн бүртгэл эсвэл Үйлчилгээтэй холбоотой гүйлгээний мэдэгдлийг маркетинг эсвэл бусад төрлийн мэдээлэл олгох мэдэгдэл гэж үзэхгүй. Компанийн зүгээс холбогдох хууль эрх зүйн зохицуулалт (ялангуяа GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн f) заалт болон Мэдээллийн нийгмийн зарим үйлчилгээний тухай 480/2004 тоот хуулийн § 7-р зүйлийн 2 дахь хэсэг), Компанийн хууль ёсны ашиг сонирхлын дагуу болон таны зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн цахим хэрэгслээр (и-мэйл гэх мэт) тантай холбогдоно. Компанийн зүгээс GDPR-ийн 6 дугаар зүйлийн 1-ийн f) заалтын дагуу өмнө байгуулсан Гэрээний хүрээнд зөвхөн Компанийн Үйлчилгээний тухай мэдээллийг танд илгээнэ.

Та хүссэн үедээ маркетинг хийхийг шууд эсэргүүцэж болно.

7. **Хадгалах хугацаа**

Компани таны хувийн мэдээллийг хуулинд заасан болон холбогдох боловсруулалтад шаардлагатай хугацаанаас хэтрүүлэн хадгалахгүй. Хадгалах хугацаа нь хувийн мэдээллийн төрөл, зорилго, хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль эрх зүйн зохицуулалтаас хамаарах тул ашиглах аргаас хамааран өөр өөр байна.

Та Компанид Хэрэглэгчийн бүртгэл үүсгэлгүй, эсвэл Компанийн Үйлчилгээг худалдаж авалгүй өөр сувгаар холбогдож байгаа, эсвэл Компанид бүртгэлээ устгахыг заагаагүй бол таныг бүртгэл үүсгэснээс хойш, эсвэл Компанитай хамгийн сүүлд харилцсанаас хойш нэг жилийн дараа Компани нэг талын шийдвэрээр таны хувийн мэдээллийг устгана.

8. **Аюулгүй байдал**

Компанийн хувьд таны хувийн мэдээллийн аюулгүй байдал чухал ч цахим орчинд мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, хадгалах ямар ч арга 100% аюулгүй байдаггүй учир Компанийн зүгээс хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг 100% хангаж чадахгүй, боломжгүй. Компани GDPR-ийн 32-р зүйлд заасны дагуу хувь хүний эрх, эрх чөлөөнд халдаж болзошгүй төрөл бүрийн, ноцтой эрсдлийг удирдах аюулгүй ажиллагааны техник болон зохион байгуулалтын зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хэрэв танд Веб сайтын аюулгүй байдал эсвэл Компанийн техник болон зохион байгуулалтын арга хэмжээний талаар асуух зүйл байвал хаягаар холбогдож болно.

9. **GDPR-ийн дагуу хувь хүний эрх**

GDPR-ийн 15 дугаар зүйлийн дагуу нэвтрэх эрх. Мэдээллийн субьектийн хувьд та хувийн мэдээллийг боловсруулж, ашиглаж байгаа эсэхийг Компаниас баталгаажуулах эрхтэй, Компани боловсруулж, ашиглаж байгаа тохиолдолд та өөрийн хувийн мэдээлэлд нэвтрэх эрхтэй.

GDPR-ийн 16-р зүйлд заасны дагуу залруулах эрх. Таны талаарх буруу мэдээллийг засаж өөрчлөхийг Компаниас нэн даруй шаардах эрхтэй.

GDPR-ийн 17-р зүйлд заасны дагуу устгуулах эрх ("мартагдах эрх"). Та тантай холбоотой болон хувийн мэдээллээ Компаниар нэн даруй устгуулах эрхтэй, Компани тодорхой шалтгааныг үндэслэн таны хувийн мэдээллийг нэн даруй устгах үүрэгтэй.

GDPR-ийн 18 дугаар зүйлд заасны дагуу боловсруулалт, ашиглалтыг хязгаарлах эрх. Тодорхой шалтгааны улмаас хувийн мэдээллийнхээ боловсруулалт, ашиглалтыг хүрээг Компаниар хязгаарлуулах эрхтэй.

GDPR-ийн 20 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэл авах эрх. Та Компанид мэдүүлсэн хувийн мэдээллээ өргөн хэрэглэгддэг загвар, цахим болон цахим бус байдлаар ашиглах боломжтой форматаар хүлээн авах эрхтэй.

GDPR-ийн 77 дугаар зүйлийн дагуу гомдол гаргах. Мэдээллийн субьектийн хувьд таны хувийн мэдээллийн боловсруулалт, ашиглалт нь хувийн мэдээллийг хамгаалах дүрмийг (GDPR) зөрчсөн гэж үзэж байгаа бол та өөрийн байнгын оршин суугаа, ажлын байр эсвэл бүрэн эрхийнхээ дагуу ажиллаж байгаа ЕХ-ны гишүүн улсын хяналтын байгууллагад гомдол гаргах эрхтэй.

GDPR-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу эсэргүүцэх эрх. Та тодорхой нөхцөл байдал, шалтгааны улмаас хувийн мэдээллийг тань цуглуулах, боловсруулах, ашиглахыг хүссэн үедээ эсэргүүцэх эрхтэй. Компанийн зүгээс хувийн мэдээллийг тань цуглуулах, боловсруулах, ашиглах зайлшгүй, ноцтой хууль ёсны шалтгааныг нотлоогүй тохиолдолд Компани цаашид таны хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах үйлдэл хийхгүй. Таны хувийн мэдээллийг маркетингийн зорилгоор боловсруулж байгаа бол та үүнийг хүссэн үедээ эсэргүүцэх эрхтэй.

Та хувийн мэдээллээ ашиглуулахаар компанид өгсөн зөвшөөрлөө шаардлагатай гэж үзсэн үедээ цуцлах бүрэн эрхтэй. Зөвшөөрлийг хүчингүй болгох нь хүчингүй болгохоос өмнөх үеийн хувийн мэдээллийг боловсруулалт, ашиглалтад нөлөөлөхгүй.

Хувийн мэдээллээ ашиглуулахаар компанид өгсөн зөвшөөрлөө хүчингүй болгох буюу цуцлах эрхээ хэрэгжүүлэх хууль эрх зүйн нөхцөл хангагдаагүй тохиолдолд оператор хувийн мэдээллийг тань устгах, түүний боловсруулалт, ашиглалтыг хязгаарлах, дамжуулахыг үйлдлийг хэрэгжүүлэхгүй байж болно (GDPR-ийн 17, 18, 20 болон 21 дугаар заалтыг үзнэ үү).

Хэрэв та холбогдох хуулийн дагуу эрхээ хэрэгжүүлэхийг хүсвэл хаягаар Компанитай холбоо барина уу. Та Компанид GDPR-ийн 9-р зүйлд заасны дагуу хувь хүний эрхийг хэрэгжүүлэх хүсэлт илгээвэл таны хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс Компани таны хувийн мэдээллийг баталгаажуулах үйлдэл гүйцэтгэж болно.

GDPR-ийн дагуу хувь хүний эрх нь Европын холбооны харьяат бус хувь хүмүүст хамаарахгүй.

МОНТО ХХК (MONTO, s.r.o.)